



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар A/253

Булган сум

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор Булган сумын 6 дугаар багийн 15, 16, 17-р гудамжны дулааны шугам өргөтгөл ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга:

Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын  
дарга)

Гишүүд:

М.Цэрэнчимэд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Г.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс,  
орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл:

Б.Туяа (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Будцэцэг (Худалдан авах ажиллагааны газрын  
мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПУРЭВ-ОЧИР

Sugar Ajil 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

• 6325010363